



Б.Явуухулан “Тэхийн зогсоол” найраглал

VIII анги



Үйл ажиллагаа

- Зохиолыг уншиж, хам сэдвийн хүрээнд мэдэрч тусган хүлээн авах
- Зохиолын өгүүлэгдэхүүн, үйл явдлын дарааллын учир холбогдлыг шинжлэн тайлбарлах
- Зохиолын орчин нөхцөл байдал нь дүрийг тодруулахад нөлөөлж буйг тайлбарлах
- Зохиогчийн үг сонголт, уран дүрслэлийн учир холбогдлоор далд утгыг тайлбарлах



Зохиолчийн товч намтар



Зохиолч Бэгзийн Явуухулан 1929 онд Завхан аймгийн Алдархаан суманд төрсөн. 1948 оноос уран бүтээлээ эхэлж, “Цэнхэр мандлын тэнгэр дор”, “Мөнгөн хазаарын чимээ”, “Хар ус нуурын шагшуурга”, “Хээр хоносон сар” “Тэхийн зогсоол”, “Намрын мөнгөн өглөө” зэрэг яруу найргийн ном хэвлүүлсэн. Шилдэг бүтээлүүд болох «*Би хаана төрөө вэ?*», «Сохор зоосны дууль», «Пионер», «Түлээчин», «Анхны цас» зохиолоороо 1967 онд Төрийн шагнал, 1979 онд соёлын гавьяат зүтгэлтэн цол тус тус хүртсэн.

Найраглал

Нэг талаас туульсын зохиол адил баатрын хэрэг явдлыг хүүрнэн өгүүлэх атлаа нөгөө талаас гол баатрын юм уу өгүүлэгчийн бодол санаа, сэтгэл хөдлөлийг илэрхийлэх шүлэглэсэн зохирлын томоохон хэлбэрийг найраглал гэнэ.

Зохиолыг уншиж, хам сэдвийн хүрээнд мэдэрч тусган хүлээн авах

Асуулт даалгаварт хариулан бичээрэй.

- Зохиолыг уншаад ямар мэдрэмж төрөв? Ямар үйл явдал хамгийн их сэтгэл хөдөлгөсөн бэ? Өөрт төрсөн сэтгэгдлээ 3 өгүүлбэрт багтаан бичээрэй.
- Өвгөн анчин оргил дээр зогсож буй янгирыг агнаагүй учир юу вэ? Ан агнах ёс заншилтай холбон тайлбарлаарай.
- Гурван гэрийнхэн яагаад нүүгээгүй вэ? Тэр хүмүүсийн сэтгэлзүйн байдал ямар байсан бэ? Зохиолоос эш татан тайлбарлаарай.
- Тэхийн халил чамд юу бодогдуулав?
- Зохиолд хүн байгалийн хүйн холбоо, жам ёс ижилхэн юм гэдгийг аль мөр бадагт илүү тод дүрсэлсэн бэ? Жишээгээр батлан тайлбарлаарай.
- Зохиолын гол санааг дүгнэн бичээрэй.


Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц

Өгүүлэгдэхүүн	Тодорхойлолт
Эхлэл	Зохиолын зөрчил эхлэх суурь дэвсгэр бүхий үйл явдлын эхлэл
Зангилаа	Зохиолын эхлэл , үйл явдал, зөрчил үүсэх шалтгааныг зангилаа гэнэ.
Өрнөл	Зохиолын зангилаанаас хойш учир шалтгааныг олохбн тулд цааш өрнөж байгаа хэсгийг өрнөл гэнэ.
Туйл	Зохиолын үйл явдал, зөрчил, тэмцэл хурцдаж туйлдаа хүрэхийг хэлнэ.
Тайлал	Зохиолын зөрчил туйлдаа хүрч улмаар хэрхэн шийдэгдэж байгааг тайлал гэнэ.
Төгсгөл	Зохиолын төгсгөлд баатруудын хувь заяа ямар болсон, зохиолч өөрөө хэрхэн үзсэн зэргээ илэрхийлснийг төгсгөл гэнэ.


Зохиолын өгүүлэгдэхүүн, үйл явдлын дарааллын учир холбогдлыг шинжлэн тайлбарлах

Зохиолын үйл явдал

Өвөлжөөндөө буусан нь




Аав хүү хоёрын харсан зүйл



Аавын яриа хот айлынханд нөлөөлсөн нь



Олон хоног харагдсан дүр зураг



Жамаараа хальсан тэх



Хаваржаа руугаа нүүлээ.



Зохиолын өгүүлэгдэхүүний задлал

Эхлэл

Тээр жилийн тэр нэгэн
өвлийн өнтэйг яана.....
Гол бараадаж 3 гэрээрээ
нүүх болов.

Зангилаа

Нэгэн өглөө аав минь
намайг ...Харлаг тэх зогсож
байна гээд бараг
хашгирав.

Өрнөл

Аав минь дуугүй, тамхиа
сорсоор гэртээ оров...
Тэр өвөлжөөнөөс хэсэгтээ
нэг л нүүхээ байв.

Туйл

Гурван гэрийн хонины
ээлж дороо эргэнэ...
Энэ л зураг олон хоногоор
өвөлжөөнд суулгав.

Тайлал

Нэгэн өглөө оргилыг
дурандаад аав орж ирэв...
Ижий өрөвдөв.

Төгсгөл

Маргааш өглөө нь гурван
гэр маань эрт ачаалав ...
Тэхийн зогсоол гэлэг тэр
оргилын өндрийг яана

Орчин нөхцөл байдал нь дүрийг тодруулахад нөлөөлж буйг тайлбарлан бичээрэй.

Үйл явдал хэзээ, хаана болж байна вэ?



Үйл явдалд ямар хүмүүс оролцож байна вэ?



Яагаад айлууд нүүхгүй удсан бэ?



Ямар үйл явдал өрнөж байна вэ? Хаана, ямар нөхцөл байдал бий болов?

Зохиолд ямар орчин дүрслэгдэж байна вэ? Ямар орчин хамгийн содон байв?

Зохиолын орчин нөхцөл

Зохиолын орчин :

- Зохиолын хэрэг явдал болж буй орон ба цагийн нэгдлийг хэлнэ.

Нөхцөл байдал:

- Дүрүүдийн хоорондын харилцааны нөхцөл байдал, дүрүүдийг үзүүлсэн орон, цагийн нийгэм, түүх, соёлын онцлогийг хэлнэ.

Цаг хугацааны хоёр өөр нөхцөлд дүрийн зан төрх хэрхэн өөрчлөгдөж байна вэ? Дүрийг тодорхойлоорой.

Дүр	Зан төрх, сэтгэл санааны байдал ямар байв?	Тэхийг харснаас хойш хэрхэн өөрчлөгдсөн бэ?
Аав		
Би		
Айлын эмээ		
Гурван гэрийнхэн		

Зохиолчийн хэл найруулга, дүрслэх хэрэглүүрийг шинжилье

1. Үгийн утга тайлбарлая

Утгыг нь огт мэдэхгүй үг		Утгыг нь мэддэг боловч хам сэдвийн хүрээнд утга нь өөрчлөгдсөн үг	
Өнтэй	Өвс цас тэгшхэн
Буйд	Гол бараадах
Хүүш	Харлаг тэх
Чандманьлах	Хонины ээлж
Бууц		

2. Янгир ямааны эр эм болон үр төлийн нэрийг мэдэж авъя

Ерөнхий нэр	Өөр нэр	Эр	Эм	Үр төл
Ямаан гөрөөс	Цагаан шил тэх-Хамгийн хөгшин том тэх	Тэх	Янгир	Өнөх-төл ишиг нь
			Багзаг тэх-шүдлэн	Хүнэн тэх- 8 настай

Дүрслэлийг задлан шинжилье

Зохиолын эшлэлийг дүрслэх үр маягтай зөв харгалзуулаарай.

Зохиолоос авсан эшлэл	Дүрслэх үр маяг
1.Өвөлжөөг хүрээлсэн уулсын оргил Бүгд өндөр Өндрийн дундаас Тэхийн зогсоол Бүр ч өндөр	А хэтрүүлэл
2. Үзүүр нь гурвалжин үүлэнд шүргэх оргил харагдав.	Б.Төлөөлөл
3. Мөнгөн оройт уулсын хишгийг их хүртлээ.	В. Ахиулал
4. Нартад түүнийг нь тэхийн зогсоол гэж нэрлэдэг юм гэнэ лээ.	Г. Хүншүүлэл
5. Өнгөрүүлсэн амьдралаа эргэж нэг хардаг юм гэнэ лээ.	Д.Адилтгал

Ахиулал

Үг хэлээр хүний сэтгэлийн хөдөлгөөн ,үйл явц өрнөлийг багаас их рүү, энгийнээс нарийн руу, эрчимжүүлэн ахиулж, илэрхийлэх давталтын өвөрмөц хэлбэрийг ахиулал гэнэ.

Дүгнэлт

Зохиолд асга хаданд дүүлж харайх харлаг тэх орчлонгийн жамаар хөгширч, өндөр оргилд гараад, ундаалдаг ариухан усаа нэг үзэж, идээлдэг сайхан бэлчээрээ нэг харж, ижил олон сүргээ эцсийн удаа нэг үзээд, эх болсон нутгаа сүүлчийн удаа нэг хараад өнгөрүүлсэн амьдралаа эргэцүүлж нэг бодоод огцом оргилоос хальж байгаа үйл явдлыг өгүүлж байна.

Хүн байгалийн хүйн холбоо, эх нутгаа энхрийлэн хайрлах үзэл, амьтны амьдралын зохилдолгоо, байгалийн улиран хувьсах үзэгдэл, төрсний эцэст үхдэг ертөнцийн жам ёсны тухай харуулсан нь уг зохиолын гол санаа юм.